



Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл

ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

Сургууль: **Техник, технологийн дээд сургууль**

Хөтөлбөр: **Барилгын инженер 073202**

Шинжээчийн баг:

Ахлагч: **Э.Нацагдорж**

Гишүүд: **Р.Хишгээ**

Т.Энхдөл

2020.11.13

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургууль /Монгол, Англи/	Техник, технологийн дээд сургууль Institute of Engineering and Technology	
Хөтөлбөр /Монгол, Англи/	Барилгын инженер	Civil Engineer
Индекс	073202	
Шинжээчид	Э.Нацагдорж	ҮБХИС-ийн Аюулгүй байдлын сургуулийн захирал
	Р.Хишгээ	ШУТИС-ийн Барилга, архитектурын сургуулийн дэд профессор
	Т.Энхдөл	МУИС-ийн Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийн дэд профессор
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Ж.Тунгалаг	
Төлөвлөгөө	Огноо	Хийгдсэн байх ажлууд
	2020.10.23	Мэргэжилтэн шинжээчдийн багийн бүрэлдэхүүнийг сонгож, ашиг сонирхлын зөрчилгүй болохыг тодруулах
	2020.10.27	Ажлын албаны захирал шинжээчийн багийг томиллох
	2020.10.28	Шинжээчтэй гэрээ байгуулан, өөрийн үнэлгээний тайланг хүлээлгэн өгч, урьдчилсан үнэлгээг эхлүүлэх
	2020.11.03	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгөх
	2020.11.04	Мэргэжилтэн, шинжээчийн багийн ахлагч сургуульд очиж бэлтгэл хангуулах
	2020.11.05 2020.11.06	Шинжээчид сургуульд очиж ажиллах
	2020.11.13	Шинжээчид үнэлгээний тайлан мэргэжилтэнд хүлээлгэн өгөх
	2020.11.17	Шинжээчийн үнэлгээний тайланг сургуульд илгээж, санал авна
	2020.11.19	Сургууль санал, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2020.11.23	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ
		Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд шинжээчийн үнэлгээний тайланг хэлэлцүүлнэ.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ы өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага”-ыг баримтлав.	

II. БАРИЛЫН ИНЖЕНЕР БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж		Барилгын тэнхим, Автозамын тэнхим				
Хөтөлбөрөөр анх элсэлт авч, сургалт эхлүүлсэн огноо		1998.09.01				
Хөтөлбөрийн (одоогийн) нэр		Барилгын инженер				
Хөтөлбөрийн индекс		D073202				
Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, хүчинтэй хугацаа		Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар 2000/74 Хүчинтэй хугацаа 2023.12.27				
Сургалтын хэлбэр		Өдөр, Эчнээ				
Суралцах хугацаа		4 жил				
Сургалт явуулдаг хэл		Монгол				
Хөтөлбөрийн өөрчлөлт (нэр, индекс, огноо)		Барилгын инженер (Иргэний ба үйлдвэрлэлийн барилга D580200 2014.07.04; Авто замын барилга D580700 2014.07.04)				
Хөтөлбөрийн хороогоор батлагдсан огноо:		2017.10.17				
Багшлах бүрэлдэхүүний нийт тоо:		25				
Үүнээс	Үндсэн	25				
	Цагийн					
	Бусад					
Боловсролын зэрэг	Доктор	3				
	Магистр	22				
Албан тушаалын зэрэглэл	Профессор	3				
	Дэд профессор	6				
	Ахлах багш	4				
	Багш	12				
Ажлын туршлага	Дагалдагч багш					
	20-оос дээш жил	8				
	11-20	10				
	6-10 жил	5				
	5 хүртэлх жил	2				
Суралцагчдын нийт тоо		2019-2020	2018-2019	2017-2018	2016-2017	2015-2016
Үүнээс	4-р курс	35	61	118	145	135
	3-р курс	66	47	104	166	153
	2-р курс	41	47	49	107	202
	1-р курс	29	31	47	90	71
Төгсөгчдийн тоо		67	72	134	171	127
Хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагын хаяг, утас, цахим хаяг		ТТДС, БГД, 10-р хороолол, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 90, Утасны дугаар: 70007630 Цахим хаяг: www.iet.edu.mn Цахим хаяг: info@iet.edu.mn				
Хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцагч эрх бүхий албан тушаалтан, түүнтэй холбогдох хаяг, дугаар		Овог нэр: Ц. Баярмаа Албан тушаал: Тэргүүн дэд захирал Утасны дугаар: 99075557 Цахим хаяг: bayarmaa.ts@iet.edu.mn				
Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн давтамж:		Анх удаа				

III. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

Шалгуур 1. ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Баримт нотолгоо:

Барилгын инженер мэргэжлээр төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь сүүлийн 5 жилийн дундаж 73% байгаа нь уг хөтөлбөрийг ажил олгогчид, үйлдвэрлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцэж байгааг харуулж байна.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, барилгын салбарын хөгжлийн чиг хандлагатай хөтөлбөрийг уялдуулах оролдлогыг хийсэн, энэ хүрээнд салбарын төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, ажил олгогч, төгсөгчдийн төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулж хөтөлбөрийг хэлэлцүүлсэн байна. Хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийг сургуулийн эрдмийн зөвлөл, захирлын зөвлөлөөр хэлэлцэж хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд тусгасан.

Дүгнэлт: 1.1 шаардлагыг бүрэн хангасан байна.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Баримт нотолгоо:

Хөтөлбөрийн зорилгыг байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, хөтөлбөрийн оролцогч талуудын хэрэгцээ шаардлага, мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгүүдийн шаардлагад нийцүүлэн 2014 онд шинээр тодорхойлж улмаар 2017, 2019 онуудад засварлан сайжруулсан.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүнг боловсруулахад ажил олгогч, төгсөгчдийн төлөөллийг оролцуулж хэлэлцэн саналыг тусгасан, олон улсын инженерийн боловсролын хөгжлийн чиг хандлага, үр дүнд суурилсан боловсролын арга зүйг тусгасан. 2017 болон 2019 онд хийсэн шинэчлэлээр хөтөлбөрийн зорилго, зорилт, суралцахуйн үр дүнд мэдлэг, чадвараас гадна хандлага, инженерийн ёс зүйг төлөвшүүлэх үзэл санааг тусгасан.

Сул тал: Хөтөлбөрийн зорилгыг задлан хөтөлбөрийн боловсролын 4 зорилтыг дэвшүүлэн, эдгээр 4 зорилтыг цааш 12 суралцахуйн үр дүн болгон задалсан байдлаас харахад нэг талаар 4 зорилт нь суралцахуйн үр дүнгээ базаж нэгтгэсэн байдалтай сайн юм шиг, нөгөө талаар ингэж давтаж авахаар суралцахуйн үр дүн тус бүр өөрөө бие даасан зорилт биш харин энэ 4 зорилтын задаргаа юм шиг ойлгогдож байна.

Дүгнэлт: 1.2 шаардлагыг бүрэн хангасан байна.

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Баримт нотолгоо:

БСШУЯ-наас тавигдаж буй шаардлагатай нийцүүлэн 2017 онд хөтөлбөрийг шинэчилж багц цагийн хуваарилалтад өөрчлөлт оруулсан. Ингэхдээ CDIO арга зүйтэй холбон Мэргэжлийн удиртгал хичээлийг нэмсэн. Хөтөлбөрийн ерөнхий болон дэд хороо байнга ажиллаж хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлэлт өгдөг. Хөтөлбөрийн агуулга, хичээлүүд нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгож чадаж байна.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Хөтөлбөрийн ерөнхий болон дэд хороогоор хөтөлбөрийг хэлэлцэж эрдмийн зөвлөлийн шийдвэрээр сургуулийн захирал баталж байгаа нь бусад сургуулиудтай адил боловч хичээлийн хөтөлбөрийг хөтөлбөрийн дэд хороо хэлэлцэж ерөнхий хороогоор батлахаас өмнө мэргэжлийн зөвлөл хэлэлцдэг давуу тал байна.

Сул тал: Сургалтын хөтөлбөрт орсон хичээлийн хөтөлбөрүүд нэг форматаар хийгдээгүй байна. Хичээлүүдийн уялдааг баримт бичгүүдэд ялгаатай байдлаар тусгасан байна.

Дүгнэлт: 1.3 шаардлагыг бүрэн хангасан байна.

ШАЛГУУР 1. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Барилгын инженер хөтөлбөрийн төлөвлөлт, баримт бичгүүд нь 2014, 2017 онд шинэчлэгдэж, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж боловсруулагдсан ба бакалаврын хөтөлбөрт тавих шаардлагуудыг хангасан байна.

Шинжээчийн дүгнэлт: Шалгуурыг БҮРЭН ХАНГАСАН байна.

Зөвлөмж:

1. Сургуулийн шаталсан сургалтын давуу тал төгсөгчдөд давуу тал болж байдгийг удирдлага, багш нар, төгсөгч, ажил олгогчид бүгд хүлээн зөвшөөрч байгааг хөтөлбөрийн зорилгод тусгах
2. Хичээлийн хөтөлбөрүүдийг нэг форматад оруулж, агуулгыг сайжруулах
3. Хичээлүүдийн уялдааг тодорхой баримт бичгүүдэд нэг мөр болгох

Шалгуур 2. СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Баримт нотолгоо:

Хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд үр дүнд суурилсан боловсролын арга зүйг нэвтрүүлэх ажлыг өргөн хүрээтэй зохион байгуулж байна. Мэргэжлийн удиртгал хичээлийг хөтөлбөрт 2 улирлаар оруулж бүтээх ур чадвар олгож байна. Хичээлүүдийн уялдааг сайжруулах, хөтөлбөрийн

суралцахуйн үр дүнг сайжруулахын тулд ерөнхий эрдмийн багш нар, мэргэжлийн багш нарын хамтын ажиллагааг дээшлүүлэхэд чиглэсэн семинар, хэлэлцүүлгийг 2017-2019 онд 4 удаа зохион байгуулсан. Хичээлийн нийлмэл хөтөлбөрийг туршин Төмөр бетон бүтээц болон Металл бүтээцийн хичээлүүдийн бие даалтын ажлыг нэгтгэн нэг төслөөр бие даалтын ажлыг бүтээлч байдлаар хийлгэх санаачилга гарган ажиллаж байна. Хөтөлбөрөөс гадуурх уралдаан тэмцээнд оюутан оролцох боломжийг хангахад анхаарч оюутны бие дааж ажиллах чадвар, бүтээх ур чадварыг дэмжиж байна.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Хөтөлбөрийн сургалтын агуулгыг суралцагчийн эзэмших цогц чадамжид нийцүүлэхэд чиглэсэн шинэчлэлийг өргөн хүрээтэй зохион байгуулж байна. Сургалтын төлөвлөгөөний матрицаар хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд хичээлүүдийн оруулж буй хувь нэмрийг харуулж, хичээлийн хөтөлбөрт хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг холбон, хичээлийн үнэлгээтэй уялдуулах оролдого хийж байна.

Сул тал: Лабораторийн хичээл ордог боловч хичээлийн хөтөлбөрт лабораторийн бус цагаар оруулсан байгааг өөрчлөх шаардлагатай. Үйлдвэрлэл дээрх сургалт нь хөтөлбөрөөс гадуурх нэмэлт дадлага байгаа бөгөөд ямар нэг байдлаар тооцогдож үнэлэгддэггүй байдлыг засах хэрэгтэй. Оюутан цаг зарцуулсан бол түүнийг ямар нэг хэлбэрээр үнэлж баталгаажуулах нь зүйтэй.

Мэргэжлийн удиртгал хичээлийг ерөнхий эрдмийн багш орж буй нь ойлгомжгүй байна.

Дүгнэлт: 2.1 шаардлагыг бүрэн хангасан байна.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Баримт нотолгоо:

Төсөлд суурилсан, асуудал шийдвэрлэхэд суурилсан уламжлалт инженерийн суралцахуйн аргуудыг өргөн хэрэглэхээс гадна идэвхитэй сургалтын арга, цахим сургалтын аргуудыг хөгжүүлэхэд сургуулийн зүгээс анхаарч байна. 2015-2020 онд нийт 12 сургалт зохион байгуулан, бүх багш нарыг идэвхитэй сургалтын арга зүйд сургасан. Багшийн заах арга зүй, ур чадварыг үнэлэн шилдэг багшийг шалгаруулдаг. Дижитал профессор төслийг хэрэгжүүлэн багш нар өөрсдийн цахим нээлттэй хичээлийг youtube сайтад байрлуулсан байна. Мэргэжлийн багш нар үйлдвэртэй танилцах дадлага, үйлдвэрлэл дээрх сургалтад хамрагдан үйлдвэрлэлийн дэвшилтэт арга технологиос хоцрохгүй байхад чиглэсэн ажлыг зохион байгуулдаг.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Багшийн заах арга зүйг дээшлүүлэхэд сургуулийн удирдлага анхаарч байна. Улирал бүрт багш өөрийн заасан хичээлийн үр дүнд үнэлгээ өгч тайланг тэнхимийн хуралд хэлэлцүүлдэг. Идэвхитэй сургалтын арга зүйг туршиж судлан, үр дүнг боловсруулан судалгааны өгүүлэл бичих хэмжээнд ажилласан багш нар байна. Дижитал профессор төслийн хүрээнд ерөнхий эрдмийн математик, хими, англи хэл, мэргэжлийн хичээлүүдээс барилгын механик, метал бүтээц зэрэг хичээлүүдийг цахим хэлбэрээр нээлттэй тавьсан сайн эхлэл байгаа ч хичээлийн агуулга бүрэн хамарсан байдлаар бэлтгэсэн хичээл цөөн байна.

Сул тал: Идэвхитэй сургалтын аргыг хэрэглээд сургалтын үр дүнд гарсан бодит ахиц ийм байна гэж нотолсон баримт бага байна.

Дүгнэлт: 2.2 шаардлагыг бүрэн хангасан байна.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Баримт нотолгоо:

Хичээлийн үр дүнг үнэлэхэд рубрик ашиглах, үнэлэх хэлбэр, заасан оноотой хамт гүйцэтгэлийн шалгуурыг заах зэргээр үнэлгээний ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлд ахиц гарч байгаа ч энэ нь цөөн тооны хичээлд хэрэглэгдсэн эхлэлийн байдалтай байна. Улирал бүрд багш өөрийн хичээлийн арга зүй, оюутны үнэлгээнд үнэлэлт өгсөн тайланг гаргаж тасралтгүй сайжруулдаг.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Суралцахуйн үнэлгээг хийхэд Блумын таксаномыг хэрэглэн оюутны хандлага, бүтээлч ажиллагааг үнэлэх оролдлого эхлэлийн байдалтай байна. Энэ талаар багш нар өөрийн үнэлгээний тайландаа тусгасан байна.

Сул тал: Төсөлд суурилсан, асуудал шийдвэрлэх сургалтын аргуудыг хэрэгжүүлж байгаа ч зарим хичээлийн улирлын шалгалтын материалуудын агуулгад асуудал шийдвэрлэх бодлого дасгал хангалтгүй байна. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг олгож чадаж буй эсэхийг хичээлийн үнэлгээгээр нотолж харуулах материал багш нарын хичээлийн хавтсуудад хангалтгүй байна.

Дүгнэлт: 2.3 шаардлагыг *бүрэн хангасан* байна.

ШАЛГУУР 2. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Суралцахуйн идэвхитэй аргуудыг хэрэглэх, төсөлт хичээлүүд, цахим хичээлүүдийг боловсруулан хэрэглэх чиглэлд тодорхой алхам хийсэн байна. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнд хичээлүүдийн оруулж буй хувь нэмрийг бодитоор харуулахад хичээлийн үнэлгээг чиглүүлэх, үнэлгээний ил тод байдлыг нэмэгдүүлэхэд анхаарч тодорхой ажлуудыг хийж байна.

Төсөллөх хичээлүүдийг үйлдвэрлэлийн хичээлүүдтэй хослуулан цөм хичээл болгохоор төлөвлөж байгааг дэмжиж байна.

Шинжээчийн дүгнэлт: Шалгуурыг **БҮРЭН ХАНГАСАН** байна.

Зөвлөмж:

1. Цахим сургалтын агуулгыг чанаржуулах
2. Хөтөлбөрийн шинэчлэлд бүх хичээл, бүх багшийг жигд хамруулах
3. Лабораторийн хичээлийн цагийг нэмэгдүүлэх

Шалгуур 3. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН, НӨӨЦ

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Баримт нотолгоо:

Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт 26263 м.кв эдлэн газартай. Барилга байгууламж, олон нийтийн иргэний барилга БНБД 31-03-03 стандартыг хангасан.

Барилгын инженер хөтөлбөрийн хүрээнд ашиглагдаж буй сургалтын танхимын нийт талбайн хэмжээ 828 м², дундаж талбай 55,2м², нэг хүнд ноогдох талбайн дундаж 2,7м² байгаа нь дээд боловсролын сургалтын орчны стандартад заагдсан шаардлагыг хангаж байна.

Хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд лекцийн заал 1, семинарын зориулалттай 5 танхим, лабораторийн зориулалттай 6 танхим, дадлагын байр 4, спорт заал, номын сан зэрэг оюутны үйлчилгээнд зориулан 6 газрыг ашиглаж байна.

Үндэсний хэмжээний “Барилгын мэргэжлийн жишиг сургууль”–иар шалгарсан байна.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Анги танхим, сургалтын тоног төхөөрөмж, сургуулийн дотоод орчны өнгө үзэмж зэргийг үе шаттайгаар тохижуулан жил бүр урсгал, их засваруудыг байнга хийж ирсэн байна.

Лаборатори, анги танхим, өрөө тасалгаа болон түүнд хэрэглэгдэж байгаа тоног төхөөрөмж нь боловсролын байгууллагад тавигдаж буй эрүүл ахуйн стандартын шаардлага, хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган ажиллахад бүрэн хангаж байна.

Сургалт орчинг сайжруулахад төгсөгчид, болон салбарынхаа тэргүүлэх компани, үйлдвэрүүдийн /Заг ХХК, Ардуурга ХХК/ оролцоог ашигладаг байна.

Сул тал: Тус сургуулийн барилга байгууламж нь олон нийтийн иргэний барилга БНБД 31-03-03 стандартыг хангасан гэх боловч цаашид хэдэн жил ашиглах боломжийг тодорхойлох үнэлгээ хийлгэх, Барилгын инженер хөтөлбөрийн хүрээнд ашиглагдаж буй тоног төхөөрөмжүүдийг тухайн хичээлийн дадлага ажлуудыг ганцаарчилан болон багаар хийх боломжтойгоор ангилан нэгтгэх шаардлагатай байна.

Дүгнэлт: 3.1 шаардлагыг бүрэн хангасан байна.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Баримт нотолгоо:

Хөтөлбөрийн багш нар өөрийн заадаг хичээлээр сурах бичиг, гарын авлага бэлтгэхээс гадна сургалтын материал - 834, интернет технологийн программ хангамж, CD, DVD, цахим хичээл 1290 цаг багтаамжтайгаар бэлтгэсэн.

2018 оноос эхлэн сургалтын үйл ажиллагаандаа “Дижитал профессор” технологийг нэвтрүүлсэн.

2015-2019 оны хичээлийн жилд лицензтэй програм хангамжийн тоо 41% өссөн ба удирдлагын менежмент систем G-SUITE /iet.edu.mn/, сургалтын зориулалтын Auto Desc-ийн багц програмууд, Adobe Creative suite, Master collection 5, Электрон, Lira 9.0, Estimator зэрэг программуудыг жилийн лицензтэйгээр ашиглаж байна

2018-2019 онд CDIO Инженерийн удиртгал хичээлийн хэрэглэгдэхүүнд БСШУСЯ-наас санаачилсан “Оюутны санаачилгыг дэмжих төсөл”-т уралдаанд багш оюутны баг оролцож “Тэргүүн байр” эзэлж 5 сая₮-ийн хөрөнгө оруулалт авч зарцуулсан.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Барилгын инженер хөтөлбөрийн хүрээнд Барилгын төлөвлөлт, Авто зам төсөллөлт, ажлын технологи, зохион байгуулалтын чиглэлийн диплом, төгсөлтийн ажил, курсын төсөл, бие даалтын ажлыг гүйцэтгэх, инженерийн программ хангамжууд дээр ажиллах, цахим номыг ашиглах, утастай болон утасгүй интернет орчинд нэвтэрч мэдээлэл боловруулахад шаардлагатай орчин үеийн тоног төхөөрөмжүүдээр тоноглогдсон.

Хичээлийн кабенит, урлан, лабораторийн шинэчлэлийг хөрөнгө оруулалтаар шийдэж байгаа туршлага байна.

Сул тал: “Дижитал профессор” технологиор хийгдсэн цахим хичээлүүдийг тухайн хичээлүүдээр /мэргэжлийн болон мэргэшүүлэх/ нь багц болгож нэгтгэх, тооцох /лекц, семинар, дадлага, лаб гэх мэт/, түүнчлэн мэргэшүүлэх хичээлд ашиглах мэргэжлийн программ хангамжийн тоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Дүгнэлт: 3.2 шаардлагыг бүрэн хангасан байна.

3.3. Сурах бичиг, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Баримт нотолгоо:

ТТДС-ийн номын сангийн уншлагын танхим 472,5м² талбайтай, 156 суудал бүхий интернет сүлжээнд холбогдсон уншигчийн хэрэгцээний 10 компьютертойгоор номын сангийн үйлчилгээ явуулж байна. Тухайн хөтөлбөрийн мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх 27 нэгж хичээлийн 257 нэр төрлийн 3048 ширхэг ном сурах бичиг ашиглагдаж байна. Тус хөтөлбөрт хамрагдах ном сурах бичиг нь нэгдсэн номын сангийн фондын 12%-ийг эзэлж байна. Электрон каталогт барилгын инженер хөтөлбөрийн 1,079 төрлийн 4,109 ширхэг ном сурах бичиг, гарын авлага, сэтгүүл, дипломын төсөл бүртгэгдсэн байна.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: “Дижитал профессор” технологиор цахим хичээлийг явуулж байгаа багш нарын туршлага нь оюутан нарт үзүүлэх үйлчилгээг бодиттой болгож байгаа сайн тал байна.

Сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэр нилээдгүй байгаас гадна төгсөгчдийн дипломын ажлуудыг номын сандаа хэрэглэдэг нь багш, суралцагчдын сурах үйл болон судалгаа шинжилгээ боловсруулалтын ажилд тустай байна.

Сул тал: Тухайн хөтөлбөрийн нэгж хичээлүүдийн цахим хичээлийн хүртээмж, чанар дээр анхаарах, оюутны бие дааж суралцах орчин, багаар ажиллах нөхцлийг номын санд болон сургуулийн орчинд бий болгох

Дүгнэлт: 3.3 шаардлагыг *бүрэн хангасан* байна.

ШАЛГУУР 3. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Тус сургууль нь 26263 м.кв эдлэн газартай ба Барилга байгууламж, олон нийтийн иргэний барилга БНБД 31-03-03 стандартыг хангасан. Тус хөтөлбөрийн хүрээнд ашиглагдаж буй сургалтын танхимын нийт талбайн хэмжээ 828 м², бүхий лекцийн заал 1, хичээлийн кабенин, семинарын зориулалттай 5 танхим, лабораторийн зориулалттай 6 танхим, дадлагын байр 4, спорт заал, номын сан зэрэг оюутны үйлчилгээнд зориулан 6 газрыг ашиглаж байна.

Эдгээр анги танхим, лаборатори, болон түүнд хэрэглэгдэж байгаа тоног төхөөрөмж нь боловсролын байгууллагад тавигдаж буй эрүүл ахуйн стандартын шаардлага, хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган ажиллах шаардлагад бүрэн нийцэж байна.

Шинжээчийн дүгнэлт: Шалгуурыг **БҮРЭН ХАНГАСАН** байна.

Зөвлөмж:

1. Тус сургуулийн барилга байгууламж нь олон нийтийн иргэний барилга БНБД 31-03-03 стандартыг хангасан гэх боловч цаашид хэдэн жил ашиглах боломжийг тодорхойлох үнэлгээ хийлгэх
2. Оюутны бие дааж суралцах орчин, багаар ажиллах нөхцлийг номын санд болон сургуулийн орчинд бий болгох
3. Мэргэшүүлэх нэгж хичээл бүр дээр виртуал орчин, бодит байдалд ойртсон даалгавруудыг дуурайлган үзүүлэх, бодитоор харуулах боломжтой сургалтын материалыг боловсруулах ажлыг эрчимжүүлэх
4. Сургуулийн байрлалаас нийтийн зам руу шилжих хэсэгт хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор ажиллах
5. Цахим хичээл болон мэргэжлийн удиртгал хичээл /CDIO арга зүйн сургалт/ бэлтгэхэд ашиглах материалыг сургуулийн төсөвт тусгаж хэрэгжүүлэх

6. Багш нар хичээлийн агуулгын шинэчлэлтэй холбоотойгоор нэгж хичээлийн үндсэн сурах бичгийн хангалтыг нэмэгдүүлэх, шинээр хөтөч сурах бичиг, гарын авлага хийх

Шалгуур 4. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежмент, маркетингийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Баримт нотолгоо:

ТТДС-ийн хэмжээнд удирдлага болон багш суралцагчдын тус бүрийн веб хуудсуудтай ба 2016-2017 оны хичээлийн жилээс эхлэн mainX.cloud удирдлагын мэдээллийн систем ашиглаж байна.

Хөтөлбөрийн удирдлагатай холбоотой эрхзүйн зохицуулалт нь Сургалтын алба, Хөтөлбөрийн ерөнхий хороо, Хөтөлбөрийн дэд хороо, мэргэжлийн зөвлөлийн оролцоотойгоор бодлого шийдвэрийг хэлэлцэн сургуулийн дүрэм журмын дагуу явагддаг байна.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Тус сургуульд хэрэгжиж байгаа хөтөлбөр нь 2016-2017 оны хичээлийн жилээс сургалтын удирдлагын системийг нэвтрүүлж, үйл ажиллагаа нь жигдэрсэн байна.

Сургалтын үйл ажиллагаанд сайжруулалт хийх зорилгоор хийгдэх асуудлуудыг хөтөлбөрийн хороо болон мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлдэг мөн мэргэжлийн чиглэлийн тандалт судалгааг ашигладаг нь сайн талтай байна.

Сул тал: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад сургалтын төлөвлөгөө, сургалтын үйл ажиллагаа, багш нар хичээлийн стандарт харах, дүн оруулах, цалингийн мэдээлэл харах, цагийн тооцоо хийх зэрэг ажиллагаанд удирдлагын мэдээлэлийн системээ бүрэн ашиглах

Хэрэглэгчээс (суралцагч, багш, оролцогч) ирсэн гомдлыг ангилан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг гарган хэмжүүрээ тодорхойлон шийдвэр гаргадаг гэсэн боловч өргөдөл гомдлын талаар мэдээлэл тайланд тусгаагүй байна.

Дүгнэлт: 4.1 шалгуурыг хэсэгчлэн хангасан байна.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Баримт нотолгоо:

ТТДС-ийн Барилгын инженер хөтөлбөрийн хүрээнд Япон улсын их сургууль /Чиба,Токио/, мөн Австрали, ОХУ, БНХАУ, БНСУ -ын сургуулиудтай гэрээ байгуулан мөн дотоодын их дээд сургууль болон төрийн, төрийн бус байгууллага, холбоодуудтай хамтран ажиллах санамж бичиг болон гэрээ байгуулж, эрдэм шинжилгээний ажилд хамтран оролцох, урт болон богино хугацааны төсөлд хамтрах, оюутнуудын танилцах, үйлдвэрлэлийн технологи, зохион байгуулалтын дадлага хийлгэх, ажлын байранд зуучлах ажлуудыг хамтран гүйцэтгэж байа.

Тухайн хичээлийн жилд оюутан солилцооны хүрээнд 4 оюутан, сургуульд зохион байгуулсан гадны багш профессоруудын сургалтанд давхардсан тоогоор 26 багш 382 оюутан хамрагдсан.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Тус сургууль нь гадны их сургуулиудтай хамтран ажиллаж, багш, оюутнуудыг солилцоогоор ажиллуулах, мэргэжлийн холбоо, ТББ-уудтай хамтран төгсөгчдийг давтан сургах, мэргэжлийн зэрэг олгох, төсөлд ажиллах зэргээр нягт хамтран ажилладаг. Тухайлбал, Монголын Авто замчдын холбоо, Барилга инженерийн холбоо зэрэг газруудтай тэнхим нь хамтран төгсөгчдөд зориулан сургалт явуулдаг.

Барилга инженерийн хөтөлбөрөөс тэнхимийн нэрэмжит Барилгын материал хичээл болон Auto Cad программын олимпиадуудыг тогтмол зохион байгуулдаг.

Сул тал: Барилгын салбарын нэгдсэн судалгаа, хөдөлмөрийн зах зээлийн судалгааг ашиглан хөтөлбөрийн тогтвортой болон идэвхтэй байдлыг хангах төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Барилгын инженер хөтөлбөрөөр суралцагчдад сургалтад ашиглах “Auto Cad”, “Estimator”, “Estimator-Pro”, “Лири-Сапр” программуудын үндсэн сургалтандаа оруулж ашиглах хэрэгтэй байна.

Дүгнэлт: 4.2 шалгуурыг бүрэн хангасан байна.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Баримт нотолгоо:

Сургалтын төлбөр судлах багц цагаар үзүүлэлт болгож оюутны суралцах үйл ажиллагаанд зарцуулдаг. Багшийн болон сургалтын үйлчилгээ олгогч ажилтны цалин, хичээл практикийн зардал, урсгал зардал зэргийг тооцож хичээлийн жилээр сургалтын төлбөрийг ТУЗ баталдаг байна.

Сургуулийн судалгаа хөгжүүлэлтийн төсөв болон тус хөтөлбөрөөр суралцагчдын сургалтын төлбөрийн 11% орчмыг хөтөлбөрийн багш нар сургах, хөтөлбөр боловсруулах, хөтөлбөрийг олон нийтэд таниулах, CDIO урлан байгуулахад зарцуулагдаж байна.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Төсвийн орлого, зарлагын төлөвлөлтөд хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн удирдлага, профессорууд оролцдоогоос гадна сургалтын шинэ арга зүйг нэвтрүүлэх, багш нарын бичсэн ном сурах бичиг хэвлүүлэх, багш нарын ажиллах нөхцөлийг сайжруулах зэрэгт тодорхой санхүүжилтийг батлуулж, авдаг.

Сул тал: Сургуулийн санхүүжилтын тухай орлого болон зарцуулалтын тайланд хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн тухай тусгагдаагүй байна. /сургалтын шинэ арга зүйг нэвтрүүлэх, багш болон суралцагчдийн үйл ажиллагааг дэмжих зардлын тухай оруулах хэрэгтэй байна./

Тайланд сургуульд дэмжлэг үзүүлсэн байгууллагын тухай тусгасан ба багш суралцагчдийг дэмжих үйл хэрэгт зарцуулсан зардлын тухай сүүлийн жилүүдээр тодорхой тусгагдаагүй байна.

Дүгнэлт: 4.3 шалгуурыг хэсэгчлэн хангасан байна.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Баримт нотолгоо:

Тус сургууль нь Монгол улсын Барилгын мэргэжлийн Жишиг сургууль болсон, мөн Ази, номхон далайн бүсийн (АРАСС) магадлан итгэмжлэлийн алтан өргөмжлөл хүртсэн.

Улсын хэмжээнд зохион байгуулагддаг “Хөрсний механик” олимпиадыг зохион байгуулдаг8 тогтмол оролцдог.

Ерөнхий боловсролын төгсөгчид болон элсэгчдэд зориулсан мэргэжил сурталчлах өдөрлөг /охид -хөвгүүд/, арга хэмжээнд оролцож, сургууль, хөтөлбөрөө сурталчилдаг.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Барилга инженер хөтөлбөрийг шинэчлэн сайжруулахад хөдөлмөрийн зах зээлийн тандах судалгаа, Хөдөлмөр нийгэм хамгааллын яам, хөдөлмөр нийгэм хамгааллын судалгааны институтаас 2015-2018 онд гаргасан барометрийн судалгааны тайлан, тус хөтөлбөрийн хичээл заадаг багш, суралцагч, төгсөгчдөөс авсан санал асуулгын үр дүн зэрэг олон талаас үнэлгээ дүгнэлт хийж ашиглаж байгаа нь сайн талтай байна.

Олон улсын ур чадварын тэмцээнд тус хөтөлбөрийн суралцагчид байнга оролцдог.

Сул тал: Тайланд хөтөлбөрийг идэвхжүүлэх талаар хийгдсэн ажлуудыг тусгасан боловч багш оюутны үйл ажиллагааг дэмжсэн, оролцуулсан тухай тусгаагүй байна.

Дүгнэлт: 4.4 шалгуурыг хэсэгчлэн хангасан байна.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Баримт нотолгоо:

Тус сургуулийн веб хуудаснаас /элсэгчдэд зориулсан болон сургалт, судалгааний мэдээлэл, хөтөлбөртэй холбоотой оюутанд зориулсан мэдээлэл/ мэдээлэл авах боломжтой ба олон нийт, иргэдэд таниулах зорилгоор хөтөлбөрийн талаар сонин, сэтгүүлийн ярилцлага өгөх, багш нарын дунд “IET багш нар” хаягаар хөтөлбөр болон өдөр тутмын шуурхай мэдээлэл солилцох зэрэг аргуудыг өргөнөөр хэрэглэж байна.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Тус сургууль нь веб хуудсандаа элсэлт болон хөтөлбөрүүдтэй холбоотой мэдээлэл, танилцуулгыг бүх талаас нь үзэх боломжтой бичлэг байдлаар хийсэн, мөн сургууль, хөтөлбөр сурталчилах тараах материалыг бэлдсэн байдлаас харагдаж байна.

Сул тал: Сургуулийн зорилго зорилтот нийцүүлэн хөтөлбөрийн маркетингийн бодлогыг сайжруулах хэрэгжүүлэх замаар олон нийтэд таниулах шаардлагатай байна.

Дүгнэлт: 4.5 шалгуурыг бүрэн хангасан байна.

ШАЛГУУР 4. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

ТТДС-ийн хэмжээнд удирдлага болон багш суралцагчдын тус бүрийн веб хуудсуудтай ба 2016-2017 оны хичээлийн жилээс эхлэн mainX.cloud удирдлагын мэдээллийн систем ашигладаг ба хөтөлбөртэй холбоотой асуудлууд сургуулийн дүрэм журмын дагуу явагддаг.

Тус сургууль нь Монгол улсын Барилгын мэргэжлийн жишиг сургууль болсон, мөн ази номхон далайн бүсийн магадланд алтан өргөмжлөл хүртсэн байна.

Мөн улсын хэмжээний уралдаан, тэмцээнүүдэд багш, оюутнуудын баг амжилттай оролцож ирсэн болон томоохон олимпиадыг зохион байгуулахад оролцдог байдал нь барилгын хөтөлбөрийг олон нийтэд таниулах, элсэгчдийг татахад нөлөөлдөг гэж үзэж байна.

Шинжээчийн дүгнэлт: Шалгуурыг ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН байна.

Шаардлага:

1. Удирдлагын мэдээлэлийн системийн агуулгыг нэвтрүүлэх, ашиглах, хяналт тавих тогтолцоог сайжруулах
2. Сургалтын үйл ажиллагааны төлөвлөгөө гарган /Хөт-ийн хороо, тэнхим/, гүйцэтгэлийн тайлан, дүн шинжилгээ хийж сайжруулах ажлуудаа тодорхой болгох, хэрэгжүүлэх
3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд анхаарч, тогтвортой байлгах, идэвхжүүлэх

тусгай төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтэд шинжилгээ хийж ажиллах

Зөвлөмж:

1. Жил бүр зохион байгуулагддаг мэргэжил сурталчилах өдөрлөгт оролцох бүрэлдхүүн болон байгууллагуудын төлөөлөгчдийн тоог нэмэгдүүлэх
2. Хөтөлбөртэй холбоотой асуудалд оролцох “Мэргэжлийн зөвлөл” -ийн үйл ажиллагааг /бие бүрэлдэхүүн, тоо, мэргэжил, агуулга/ тодорхой болгох
3. Мэргэшсэн инженерийн сургалт, мэргэшсэн төсөвчин зэрэг сургалтуудад төгсөгчдөө зуучилж суралцуулахаас гадна хөтөлбөрийн багш нар тодорхой хичээлүүдийг заах, зохион байгуулах байдлаар цаашид оролцох боломжийг эрэлхийлэх
4. Нэг оюутанд ногдох өртөг зардлын тооцоог сүүлийн 3 хичээлийн жилээр тооцож тайлангаар харуулах

Шалгуур 5. СУРАЛЦАГЧИД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Баримт нотолгоо:

Оюутан элсүүлэх дүрэм, журам (<https://www.iet.edu.mn>), бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах сургалтын журам нь тогтвортой хэрэгжиж байна.

Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланд элсэгчдийн ЭЕШ-ын дундаж үзүүлэлт (2015-2019 он)-ийг гаргаж, шинжилгээ хийж дүгнэлт гаргасан байна.

Шинэ элсэгчдэд зориулж сургуулийн вэб хуудсаар /Оюутны цахим гарын авлага үзэх холбоос: iet.edu.mn/оюутны-гарын-авлага/; мөн сургуулийн сургалтын орчинтой цахимаар танилцах /360 аялах/: <https://iet.edu.mn/360/1/index.php/> дамжуулан видео танилцуулга хийж, мэдээлэл түгээдэг.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Тус сургууль нь мэргэжлийн боловсролоор, техникийн боловсролоор дамжин дээд сургуульдаа шилжин суралцах боломжтой шаталсан сургалт юм. Мөн тус сургууль нь өөрийн бүрэлдэхүүнд техник технологийн политехник коллежтэй ба Ази номхон далайн бүсийн магадлан итгэмжлэлийн алтан өргөмжлөлтэй нь нэр хүнд болон сургалтын орчны бэхжилт сайтайг сурталчилснаар элсэгчдийн тоог нэмэгдүүлэх бодлого болж байна.

ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад чиглэсэн сургуулийн нээлттэй хаалганы өдөрлөг, уулзалт, сургалтыг тогтмол зохион байгуулж ажилладаг.

Сул тал: Элсэгчдийн ЭЕШ-ын дундаж үзүүлэлтээс (2015-2019 он) харахад физик, математикийн хичээлийн онооны дундаж буурсан. Элсэлтийн тоо харьцангуйгаар багасаж байгаа байдалд анхаарч төлөвлөгөө гарган ажиллах хэрэгтэй байна.

Шинээр элсэгчдэд зориулсан хөтөлбөрийн мэдээлэл бүхий зөвлөмж, гарын авлагатай болох шаардлагатай байна.

Дүгнэлт: 5.1 шалгуурыг бүрэн хангасан байна.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл

зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Баримт нотолгоо:

Сургуулийн хувьд оюутны суралцах судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт сэтгэл зүй, төлөвшлийн чиглэлээр зөвлөх үйлчилгээг оюутны хөгжил үйлчилгээний хэлтсээр дамжин хэрэгждэг. Оюутны клубын оролцогчдын хийсэн бүтээлүүд, шагналууд /Бүтээгч Монгол баг/, олон улсын тэмцээнд тогтмол оролцож буй байдал /Төмөрбетоны аян , Ган Гүүр / төгсөгчид болон суралцагчдтай хийсэн уулзалт, ярилцлага зэргээр тайланд тодорхой тусгасан байна.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Суралцагчдад ирээдүйн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр зөвлөл, төвүүдийг ажилуулдаг, мөн бүтээгч монгол багын үйл ажиллагааг ТТДС-ийн хэмжээнд тогтмол зохион байгуулдаг.

Суралцагчдын суралцах, судлах арга зүйд зөвлөх багш ажилуулж зөвлөн туслах үйлчилгээг үзүүлдэг, төрөл мэргэжлийн багш нараас бие хүний төлөвшил, харилцаа ёс зүйн чиглэлийн сургалтуудыг зохион байгуулдагт оюутнууд сэтгэл ханамжтай байна.

Сул тал: Хөтөлбөрийн дагуу мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг зохион байгуулдаг боловч оюутнууд энэ чиглэлээр тодорхой, тогтмолжсон үйл ажиллагаа явуулах, бодит амьдралтай нийцүүлэх хүсэлтийг /норм, дүрэм, дадлагын хугацаа/ ярьж байгаа нь энэ үйл ажиллагааг явуулж буй агуулга, хэлбэрийг өөрчилж, хүртээлтэй болгох шаардлага байгааг харуулж байна.

“Мэргэжлийн удиртгал” хичээлийн агуулга, арга зүйг оюутны сэтгэлгээ, цаг үеийн онцлогт тохируулан сайжруулах шаардлага харагдаж байна.

Дүгнэлт: 5.2 шалгуурыг бүрэн хангасан байна.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Баримт нотолгоо:

Оюутны байгууллагаас /“Оюутны хөгжил” хөтөлбөр/ санаачилсан нийгэмд үзүүлэх үйлчилгээг дэмжин хамтран ажилладаг. Суралцагчдын амжилтыг хөхүүлэн дэмжих урамшууллын системтэй байна.

Оюутны гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлэх эрх зүйн зохицуулалтыг хийсэн. Сургуулийн журманд заасан шагнал, урамшууллын гадна сургуулийн зүгээс оюутанд кредитийн урамшуулал олгодог журмыг мөрддөг байна.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Оюутнууд жил бүр “охид, хөвгүүдийн өдөрлөг”, гэмт хэрэг, зөрчилтэй холбогдох байдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд сайн дураар оролцдог.

Оюутны “Бүтээгч монгол” клубтэй, клубын үйл ажиллагаанд оюутнууд идэвхтэй оролцдог, сургуулийн, үндэсний, олон улсын чанартай тэмцээнүүдэд амжилттай оролцдог туршлагатай.

Оюутны зохион бүтээх чадвар, асуудал шийдвэрлэх чадваруудыг хөгжүүлэхийг зорьдог. Бүх шатны уралдаан тэмцээнд оролцсон оюутнуудаа урамшуулдаг урамшууллын тогтолцоо хэрэгжиж хэвшсэн.

Сул тал: Оюутны клубүүдийн үйл ажиллагаа тогтмол боловч шинээр элсэж буй, мөн бага бүлгийн оюутнуудад клубийн мэдээлэл дутмаг байдгаас оролцож чаддаггүй тохиолдол гарч байгааг анхаарч ажиллах шаардлагатай байна.

Дүгнэлт: 5.3 шалгуурыг бүрэн хангасан байна.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Баримт нотолгоо:

Сургуулийн оюутанд чөлөө олгох, оюутны шилжилт хөдөлгөөн, хөтөлбөр хооронд шилжих, сургуулиас хасах, чөлөөлөх үйл ажиллагааг “Оюутны шилжилт хөдөлгөөний журам”-аар зохицуулдаг. /Дүрэм журмын эмхэтгэл-1.11 заалт/.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Сургалтын албан дээр оюутны үйлчилгээний төвөөр дамжин сургалт эрхэлсэн захирлын шийдвэрээр оюутны шилжилт хөдөлгөөнийг зохицуулж, зохих журмын дагуу шийдвэрлэдэг.

Сул тал: Тус сургуулиас жилийн чөлөө авсан оюутнуудын тоо нь 1-2-р бүлгийн дунд их байна. Шалтгааныг үзэхэд ар гэрийн гачигдал, төлбөрийн боломжгүй байдал нь давамгайлж байна. Иймээс суралцагчдын тогтвортой байдлыг хангах арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй.

Шилжин ирэгсэд болон ялангуяа шатлан суралцагчдын тоог нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллах хэрэгтэй.

Дүгнэлт: 5.4 шалгуурыг бүрэн хангасан байна.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Баримт нотолгоо:

Сургуулийн дээд боловсролын дүрэм журмын эмхэтгэлийн 1.10 зүйлээр дипломын төсөл /ажил/ хамгаалуулах, төгсөлтийн асуудлыг зохицуулдаг. Төгсөгчдөд олгосон диплом, дипломын хавсралтад хөтөлбөрийн нэр, индекс, судалсан хичээл, бакалаврын судалгааны ажлын сэдэв, гүйцэтгэлийг харгалзах оноо, үсгэн дүнгээр бичиж баталгаажуулсан байна. Диплом, дипломын хавсралтыг монгол, монгол бичигээр хэвлэсэн байна.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Барилгын инженер хөтөлбөрийн бакалаврийн дипломны загвар болон агуулгын хувьд тогтсон загвар, стандарт, зохих шаардлагуудыг багтаасан байна.

Сул тал: Төгсөлтийн баримт бичгийг үрэгдүүлсэн тохиолдолд дахин олгох боломжийн тухай тусгаж өгсөн байх

Дүгнэлт: 5.5 шалгуурыг бүрэн хангасан байна.

ШАЛГУУР 5. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Тус сургууль нь мэргэжлийн болон техникийн боловсролоор дамжин дээд сургуульдаа шилжин суралцах боломжтой, Ази, номхон далайн бүсийн (АРАСС) магадлан итгэмжлэлийн алтан өргөмжлөлтэй, ЕБС-ийн ахлах ангийнханд чиглэсэн өдөрлөг зэргийг зохион байгуулдаг боловч тлсэлтийн тоо харьцангуйгаар багасаж байна. Шинээр элсэгчдэд зориулсан хөтөлбөрийн мэдээлэл бүхий зөвлөмж, гарын авлагыг боловсруулах, элсэгчдийн тоог нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Хөтөлбөрийн дагуу мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг зохион байгуулдаг боловч оюутнууд энэ чиглэлээр тодорхой, тогтмолжсон үйл ажиллагаа явуулах, бодит амьдралтай нийцүүлэх хүсэлтийг /норм, дүрэм, дадлагын хугацаа/ ярьж байгаа нь энэ үйл ажиллагааг явуулж буй агуулга, хэлбэрийг өөрчилж, хүртээлтэй болгох шаардлага байна.

Тус сургуулиас жилийн чөлөө авсан оюутнуудын тоо нь 1-2-р бүлгийн дунд их байна.

Шалтгааныг үзэхэд ар гэрийн гачигдал, төлбөрийн боломжгүй байдал нь давамгайлж байна. Иймээс суралцагчдын суралцах үйлийн тогтвортой байдлыг хангахад анхаарах.

Дүгнэлт: Шалгуурыг БҮРЭН ХАНГАСАН байна.

Зөвлөмж:

1. Оюутны элсэлтийг нэмэгдүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтийг элсэгчийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хэлбэрээр, үр бүтээлтэй зохион байгуулах, сурлагын амжилтаар, бүтээлээр тэргүүлэгч оюутнуудыг алдаршуулах, урамшуулах шинэ аргуудыг нэвтрүүлэх
2. Сургуулиас гадагш чиглэсэн олон нийтийн үйл ажиллагааны төрлийг нэмэгдүүлэх
3. Суралцагчийн тоог нэмэгдүүлэх, хэл сураггүй сургуулиа орхих, жилийн чөлөө авч буй оюутнуудын судалгааг хийж, эргэх холбоотой ажил зохион байгуулах
4. Элсэгчдэд зориулсан хөтөлбөрийн мэдээлэл бүхий зөвлөмж, гарын авлагатай болох
5. Дээдэд элссэн оюутнуудыг шаталсан сургалтаар дамжсан оюутнуудтай адил арга зүй, түвшинд суралцах боломжийг бүрдүүлэх
6. Зөвлөх багшийн ажлын чиглэлд оюутнуудыг олон нийтийн ажиллагаанд оролцуулах ажиллагааг нэмэгдүүлэх, хэрэгжүүлэх, хянах
7. Дипломын хавсралтад эзэмшсэн агуулга, хөтөлбөрийн үр дүнг тусгаж оруулах

Шалгуур 6. БАГШИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Баримт нотолгоо:

Багш нарыг нээлттэй сонгон шалгаруулалт зарлан авдаг. Нийт багш нарын 23% доктор , 77% магистр, 6 докторант байгаа нь тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшлах боловсон хүчин сайн бүрдсэн. Практик дээр ажиллаж байсан туршлагатай багш нартай байгаа нь хөтөлбөрөөр эзэмших чадварыг хөгжүүлэхэд чухал нөлөөтэй байна.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Багшийн сонгон шалгаруулж авах, зэрэглэл ахиулах болон урамшууллын бодлого тодорхой нээлттэй, хөтөлбөрийн багш нар ахисан түвшний зэрэгтэй байгаа нь тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх боловсон хүчний мэргэжлийн чадвар, туршлага хангалттай байна гэж дүгнэж байна.

Сул тал: Докторантад суралцаж байгаа багш нарыг хамгаалуулах нөхцлийг мөн магистр зэрэгтэй багш нарыг ахисан түвшний сургалтанд хамруулах боломжууд байна.

Дүгнэлт: 6.1 шаардлагыг бүрэн хангасан байна.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Баримт нотолгоо:

Багшийн хөгжилд анхаарч хичээлийн жил бүр зочин лектор болон дотооддоо туршлага хуваалцах сургалтыг зохион байгуулдаг. 2013-2016 оны ТТДС-ийн стратеги төлөвлөгөө, болон

хичээлийн жилд “Багшийн хөгжил” хөтөлбөрт залуу багш нарыг ахмад туршлагатай багш дагалдуулан ажиллуулах төлөвлөгөө гарган ажилласан. 2014-2019 оны хичээлийн жилд нийт зочин багшийн сургалт 39, арга зүйн чиглэлээр 49 сургалтыг багш нартаа зориулан зохион байгуулжээ.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Оюутанаас гадна багш нарыг мэргэжлийн буюу ажил олгогчдтой холбон богино хугацааны томилолтоор ажиллуулж бодит нөхцөлд нэвтэрч байгаа арга технологиудыг мэдүүлж байгаа нь сайн.

Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулж байгаа нь сайн. Ерөнхий эрдмийн багш нартай улиралд 2 удаа уулзан тус хөтөлбөрийн үр дүн, агуулгыг харилцан санал солилцож, хичээлийн бус хөтөлбөрийн багш болгох үйл ажиллагаа хийж байгаа нь сайшаалтай байна. Багшийг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулж, тогтмол хэрэгжүүлж хөтөлбөрийн сургалтын арга технологид өөрчлөлт шинэчлэлт хийж байна.

Сул тал: Гадаад, дотоод томилолтын үр дүнд сургалтанд нэвтрүүлэх шинэ арга зүй, сургалтын технологийн ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийг сайжруулах боломжтой.

Дүгнэлт: 6.2 шаардлагыг *бүрэн хангасан* байна.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Баримт нотолгоо:

Багш нар бусад их, дээд сургууль болон ажил олгогчдын хүсэлтийн дагуу судалгаа шинжилгээний ажил хийж үр дүнг сургуулиас эрхлэн гаргадаг сэтгүүлд хэвлүүлдэг. Дээд сургууль ч гэсэн судалгаа, инновацийн бүтээгдэхүүн гаргаж оюуны өмчийн баталгаажуулалтыг хийдэг.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагааг хөгжүүлэх потенциал байгаа ба ажиллах орчин ч хангалттай бүрэлдэж, багш нар ажил олгогчдтой хамтран судалгааны ажилд оролцдог.

Сул тал: Шинэ бүтээл, ашигтай загвар гаргах боломж тус хөтөлбөрийн багш нарт байгаа учир энэ төрлийн үйл ажиллагааг дэмжиж урамшуулах зохицуулалга дутмаг байна. Бусад их, дээд сургуультай хамтарсан төсөл хөтөлбөрүүдэд оролцох нь сүүлийн жилүүдэд буурсан байна.

Дүгнэлт: 6.3 шаардлагыг *бүрэн хангасан* байна.

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Баримт нотолгоо:

Хичээлийн жил бүр багшийн үйл ажиллагааг үнэлэх журам, төлөвлөгөө, тайланг тогтмол авч хэвшсэн.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Багшийн үйл ажиллагааны тайланг тогтмол авч, хөтөлбөртэй холбоотойгоор үнэлгээ хийх болсон нь сайшаалтай, цаашид хөтөлбөрийн үр дүн, заах арга зүй, орчинтой холбоотой үнэлгээний үр дүнг хөтөлбөрийн хөгжүүлэх төлөвлөгөөнд тогтмол тусган ажиллах хэрэгтэй байна

Сул тал: Багшийн өөрийн үнэлгээний тайланг хөтөлбөрийн ахлагч анхааран, цаашид

сайжруулах үйл ажиллагаа нь дутмаг байна.

Дүгнэлт: 6.4 шаардлагыг хэсэгчилэн хангасан.

ШАЛГУУР 6. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Багшийн үйл ажиллагаа, заах арга зүй болон багшийн хөгжил, үнэлгээтэй холбоотой үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж хэвшсэн.

Шинжээчийн дүгнэлт: Шаардлагыг БҮРЭН ХАНГАСАН байна.

Зөвлөмж:

1. Багшийн дотоод, гадаад томилолттой холбоотойгоор гаргасан цаашид хийх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг харах
2. Багшийн өөрийн үнэлгээний тайланд үндэслэн хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг тогтмол хийж хэвших

Шалгуур 7. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ, БАТАЛГААЖИЛТ

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Баримт нотолгоо:

Дотоод чанарын баталгаажуулалтыг хариуцсан мэргэжилтэн, нэгжийг үүсгэсэн. 2 үе шаттай чанарын баталгаажуулалтыг хийдэг.

Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг хийх ажлын төлөвлөгөө болон оролцогч талуудыг тусгасан байна.

Шинжээчийн үнэлгээ:

Чанарын баталгаажуулалтын нэгж хөтөлбөрийн ахлагч болон багш нартай нягт холбоотой ажиллан, заавар зөвлөмжийг өгч байх хэрэгтэй байна.

Сул тал: Багшийн өөрийн үнэлгээний тайлан, хөтөлбөрийн үнэлгээ болон оюутны сэтгэл ханамжийн судалгаануудыг нэгтгэн тус хөтөлбөрийг хөгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн ажиллах сул байна.

Дүгнэлт: 7.1 шаардлагыг хэсэгчилэн хангасан байна.

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Баримт нотолгоо:

Хөтөлбөрийн үр дүнг оролцогч талуудаас санал асуулга аван баталгаажуулдаг. Хөтөлбөр зорилтод үр дүнд хүрсэн байдлын индикаторыг ажил эрхлэлт хэмээн үзэж төгсөгчдийг мөшгих судалгааг тогтмол зохион байгуулдаг.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Төгсөгчид, суралцагчид, ажил олгогчид хөтөлбөрийн үр дүн буюу олгож байгаа мэдлэг, чадвар, хандлагад өөрийн саналыг тусгахад идэвхитэй оролцож хөтөлбөрийг сайжруулдаг.

Сул тал: Санал асуулгаар дунджаас дээш үнэлгээтэй байгаа ч суралцахуйн үр дүнгийн хэрэгжилтийг сайжруулах санаачлагыг тусган ажиллах нь дутмаг байна.

Дүгнэлт: 7.2 шаардлагыг бүрэн хангасан байна.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Шаардлагатай бол олгож буй эрдмийн зэрэг болон мэргэжлийн нэр хүндийг дэмжих зорилгоор үндэсний болон олон улсын байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэдэг байна.

Баримт нотолгоо:

Тус хөтөлбөрөөр төгсөгч нь дотоод, гадаадын их дээд сургуульд ахисан түвшний сургалтанд хамрагдаж багааг тусгасан. Дотоодын болон олон улсын уралдаан тэмцээнд тогтмол оролцож оюутнуудын чадварыг хөгжүүлдэг.

Шинжээчийн үнэлгээ:

Давуу тал: Тус хөтөлбөр нь төгсөгчийн чанар болон бусад практик чадварыг хөгжүүлж байгаагаараа үндэсний хэмжээнд ажил олгогчдын дунд танигдсан хөтөлбөр болсон нь маш том боломж. Тус хөтөлбөр нь ажил олгогчдоор бүрэн хүлээн зөвшөөрөгдөж танигдсан хөтөлбөр болсон байна.

Сул тал: Ахисан түвшний сургалтанд хамрагдах төгсөгчийн тоо бага байгаа нь сул тал болж байна.

Дүгнэлт: 7.3 шаардлагыг бүрэн хангасан байна.

ШАЛГУУР 7. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ:

Хөтөлбөрийн үр дүнг оролцогч талуудаар баталгаажуулах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж хөтөлбөрийг сайжруулах үйл ажиллагааг хийж байгаа. Төгсөгчдийн эзэмшвэл зохион мэдлэг, чадвар, хандлагыг сайн төлөвшүүлж улмаар ажил олгогчдод танигдаж хүлээн зөвшөөрөгдсөн байна. Тус хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт болон оролцогч талуудыг оролцуулан хөтөлбөрийг сайжруулах үйл ажиллагааг хийдэг.

Шинжээчийн дүгнэлт: Шалгуурыг БҮРЭН ХАНГАСАН байна.

Зөвлөмж:

1. Багшийн өөрийн үнэлгээний тайлан, хөтөлбөрийн үнэлгээ болон оюутны сэтгэл ханамжийн судалгаануудыг нэгтгэн тус хөтөлбөрийг хөгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн ажиллах

ШИНЖЭЭЧИЙН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ:

.....
.....

ШИНЖЭЭЧИЙН ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан шаардлага (2)	Хэсэгчлэн хангасан шаардлага (1)	Хангаагүй шаардлага (0)	Үнэлгээ, дүгнэлт
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	1.1, 1.2, 1.3			Бүрэн хангасан
2	Сургалтын үйл ажиллагаа	2.1, 2.2,			Бүрэн хангасан
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3.1, 3.2, 3.3			Бүрэн хангасан
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4.2, 4.5	4.1, 4.3, 4.4		Хэсэгчлэн хангасан
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5			Бүрэн хангасан
6	Багшийн үйл ажиллагаа	6.1, 6.2, 6.3,	6.4		Бүрэн хангасан
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	7.2, 7.3	7.1		Бүрэн хангасан
Нэгдсэн дүгнэлт		БҮРЭН ХАНГАСАН			

Өөрийн үнэлгээний тайлан, нотлох баримт, уулзалт ярилцлагын тэмдэглэлд үндэслэн шинжээчийн баг “Барилгын инженер” бакалаврын хөтөлбөр нь БМИҮЗ-ийн дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурыг “БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, чанарыг цаашид сайжруулах чиглэлээр дараах шаардлага/зөвлөмжийг өгч, шинжээчийн багийн дүгнэлтийг Боловсролын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

ШИНЖЭЭЧИЙН ШААРДЛАГА

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт	<ol style="list-style-type: none"> Удирдлагын мэдээлэлийн системийн агуулгыг нэвтрүүлэх, ашиглах, хяналт тавих тогтолцоог сайжруулах Сургалтын үйл ажиллагааны төлөвлөгөө гарган /Хөт-ийн хороо, тэнхим/, гүйцэтгэлийн тайлан, дүн шинжилгээ хийж сайжруулах ажлуудаа тодорхой болгох, хэрэгжүүлэх Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд анхаарч, тогтвортой байлгах, идэвхжүүлэх тусгай төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтэд шинжилгээ хийж ажиллах
---	---

ШИНЖЭЭЧИЙН ЗӨВЛӨМЖ

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ol style="list-style-type: none"> 1. Сургуулийн шаталсан сургалтын давуу тал төгсөгчдөд давуу тал болж байдгийг удирдлага, багш нар, төгсөгч, ажил олгогчид бүгд хүлээн зөвшөөрч байгааг хөтөлбөрийн зорилгод тусгах 2. Хичээлийн хөтөлбөрүүдийг нэг форматад оруулж, агуулгыг сайжруулах 3. Хичээлүүдийн уялдааг тодорхой баримт бичгүүдэд нэг мөр болгох
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ol style="list-style-type: none"> 4. Цахим сургалтын агуулгыг чанаржуулах 5. Хөтөлбөрийн шинэчлэлд бүх хичээл, бүх багшийг жигд хамруулах 6. Лабораторийн хичээлийн цагийг нэмэгдүүлэх
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин технологийн нөөц	<ol style="list-style-type: none"> 7. Тус сургуулийн барилга байгууламж нь олон нийтийн иргэний барилга БНБД 31-03-03 стандартыг хангасан гэх боловч цаашид хэдэн жил ашиглах боломжийг тодорхойлох үнэлгээ хийлгэх 8. Оюутны бие дааж суралцах орчин, багаар ажиллах нөхцлийг номын санд болон сургуулийн орчинд бий болгох 9. Мэргэшүүлэх нэгж хичээл бүр дээр виртуал орчин, бодит байдалд ойртсон даалгавруудыг дуурайлган үзүүлэх, бодитоор харуулах боломжтой сургалтын материалыг боловсруулах ажлыг эрчимжүүлэх
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт	<ol style="list-style-type: none"> 10. Жил бүр зохион байгуулагддаг мэргэжил сурталчилах өдөрлөгт оролцох бүрэлдхүүн болон байгууллагуудын төлөөлөгчдийн тоог нэмэгдүүлэх 11. Хөтөлбөртэй холбоотой асуудалд оролцох “Мэргэжлийн зөвлөл ” - ийн үйл ажиллагааг /бие бүрэлдэхүүн, тоо, мэргэжил, агуулга/ тодорхой болгох 12. Мэргэшсэн инженерийн сургалт, мэргэшсэн төсөвчин зэрэг сургалтуудад төгсөгчдөө зуучилж суралцуулахаас гадна хөтөлбөрийн багш нар тодорхой хичээлүүдийг заах, зохион байгуулах байдлаар цаашид оролцох боломжийг эрэлхийлэх 13. Нэг оюутанд ногдох өртөг зардлын тооцоог сүүлийн 3 хичээлийн жилээр тооцож тайлангаар харуулах
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	<ol style="list-style-type: none"> 14. Оюутны элсэлтийг нэмэгдүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтийг элсэгчийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хэлбэрээр, үр бүтээлтэй зохион байгуулах, сурлагын амжилтаар, бүтээлээр тэргүүлэгч оюутнуудыг алдаршуулах, урамшуулах шинэ аргуудыг нэвтрүүлэх 15. Сургуулиас гадагш чиглэсэн олон нийтийн үйл ажиллагааны төрлийг нэмэгдүүлэх 16. Суралцагчийн тоог нэмэгдүүлэх, хэл сураггүй сургуулиа орхих, жилийн чөлөө авч буй оюутнуудын судалгааг хийж, эргэх холбоотой ажил зохион байгуулах 17. Элсэгчдэд зориулсан хөтөлбөрийн мэдээлэл бүхий зөвлөмж, гарын авлагатай болох 18. Дээдэд элссэн оюутнуудыг шаталсан сургалтаар дамжсан оюутнуудтай адил арга зүй, түвшинд суралцах боломжийг бүрдүүлэх

	19. Зөвлөх багшийн ажлын чиглэлд оюутнуудыг олон нийтийн ажиллагаанд оролцуулах ажиллагааг нэмэгдүүлэх, хэрэгжүүлэх, хянах 20. Дипломын хавсралтад эзэмшсэн агуулга, хөтөлбөрийн үр дүнг тусгаж оруулах
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	21. Багшийн дотоод, гадаад томилолттой холбоотойгоор гаргасан цаашид хийх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг харах 22. Багшийн өөрийн үнэлгээний тайланд үндэслэн хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг тогтмол хийж хэвших
Шалгуур 7. Чанарын баталгаажуулалт	23. Багшийн өөрийн үнэлгээний тайлан, хөтөлбөрийн үнэлгээ болон оюутны сэтгэл ханамжийн судалгаануудыг нэгтгэн тус хөтөлбөрийг хөгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн ажиллах

Шинжээчийн багийн ахлагч Э.НАЦАГДОРЖ
Шинжээчийн багийн гишүүн Р.ХИШГЭЭ
Шинжээчийн багийн гишүүн Т.ЭНХДӨЛ

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Багшийн нэр	Албан тушаал	Заадаг хичээл	Утас	Майл хаяг

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс, түвшин	Сонгосон байдал	Утас	Майл хаяг
		1	Орон нутгийн		
		2	Хөгжлийн бэрхшээлтэй		
		3	Клубын гишүүн		

III. Ажил олгогчдын нэрс

№	Ажил олгогчийн нэр	Байгууллага, албан тушаал	Утас	Майл хаяг

IV. Төгсөгчдийн нэрс

№	Төгсөгчийн нэр	Төгссөн он	Байгууллага, албан тушаал	Утас	Майл хаяг

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Шаардлага, зөвлөмж

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Шаардлага, зөвлөмж